



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

### Нийслэлийн түргэн тусламжийн төвийн данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/172 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэгдсэн нийт 104,250,000 /нэг зуун дөрвөн сая хоёр зуун тавин мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан 2 тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн түргэн тусламжийн төв /Ц.Пүрэвдаш/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг актлан сэлбэгийн зориулалтаар фондолж, ашиглалтын шаардлага хангахгүй болон илүүдэлтэй сэлбэгүүдийг хоёрдогч түүхий эд, сэлбэгийн зориулалтаар 1,000,000 /нэг сая/ төгрөгнөөс доошгүй үнээр худалдан борлуулж зохих дансанд нь орлого болгон авахыг Нийслэлийн түргэн тусламжийн төв /Ц.Пүрэвдаш/-д үүрэг болгосугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Нийслэлийн түргэн тусламжийн төв /Ц.Пүрэвдаш/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс /Д.Итгэл/-т тус тус даалгасугай.

ДАРГА




Ч.ОДНАСАН

ТТА-2371

115050000155

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
2019 оны 03 дугаар сарын 13 -ны өдрийн  
А/Ю дугаар тушаалын хавсралт



**ЭЗЭМШИГЧ БАЙГУУЛЛАГАД НЬ СЭЛБЭГИЙН ЗОРИУЛАЛТААР  
АШИГЛУУЛАХААР ШИЙДВЭРЛЭГДСЭН  
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛҮҮД**

/төгрөгөөр/

| №               | Байгууллагын нэр      | Марк, дугаар              | Баланс үнэ         | Үйлдвэрлэгдсэн он | Нийт гүйлт мян.км | Байгуулагдсан элэгдэл | Үлдэгдэл үнэ |
|-----------------|-----------------------|---------------------------|--------------------|-------------------|-------------------|-----------------------|--------------|
| 1               | Түргэн тусламжийн төв | Хьюндай Старекс 05-81 УНБ | 37,950,000         | 2009/2009         | 353048            | 37,950,000            | -            |
| 2               |                       | Хьюндай Старекс 38-22 УНП | 66,300,000         | 2009/2012         | 185500            | 66,300,00             | -            |
| <b>Нийт дүн</b> |                       |                           | <b>104,250,000</b> |                   |                   | <b>104,250,000</b>    | <b>0</b>     |